

ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ ЗАРЛАЛ

2020.02.18

Улаанбаатар хот

1. **Нийслэлийн Авто замын хөгжлийн газар** дараах ажлыг хэрэгжүүлэх зорилгоор зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулах гэж байгаа тул зөвлөхийн үйлчилгээ үзүүлэх хүсэлтэй этгээдийг мэдүүлгээ ирүүлэхийг урьж байна.
2. **Энэхүү Инженер техникийн ажилчдыг салбарын чиглэлээр мэргэшүүлэх, бэлтгэх зөвлөх үйлчилгээ нь** зарлаж байна. Үүнд:
Багц-4 Төрийн захиргаа хүний нөөцийн чиглэлээр багц сургалт зохион байгуулах

Мэдүүлгээ ирүүлж буй зөвлөх нь уг үйлчилгээг гүйцэтгэх чадвартайг нотлох дараахь мэдээллийг ирүүлнэ.

1. Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбарыг нотариатаар баталгаажуулж ирүүлэх
2. Сургалт явуулах эрх бүхий байх / нотлох баримт ирүүлэх /
3. Ижил төстэй сургалт явуулж байсан туршлагын талаарх мэдээлэл /2017, 2018, 2019он/
4. Зөвлөх хуулийн этгээдийн ажиллах боловсон хүчний чадавхийн талаарх мэдээлэл / сургагч багш нарын ур чадварын мэдээлэл , туршлага холбогдох баримт бичгүүд /
5. Зөвлөх хуулийн этгээдийн санхүүгийн чадавхийн мэдээлэл /Сүүлийн 3 жилийн/ 2017, 2018, 2019 он/ санхүүгийн тайлангийн аудитаар баталгаажуулсан дүгнэлт/
6. Сүүлийн 3 жил буюу 2017, 2018, 2019 онуудын аль нэг жилд ижил төстэй зөвлөх үйлчилгээ үзүүлсэн байх
7. Улсын бүртгэлийн гэрчилгээнд заасан харьяалагдах банк, нийгмийн даатгал, Шүүхийн төрөлжсөн архивын тодорхойлолт, Нийслэлийн Захиргааны хэргийн шүүхийн тодорхойлолт болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын тодорхойлолт ирүүлнэ.
8. Монгол Улсын, эсхүл үүсгэн байгуулагдсан улсын хуулийн дагуу татвар, ураамж, төлбөрөө тухайн тендер нээсэн өдрийн байдлаар бүрэн төлсөн тухай баримт / сүүлийн 10,11,12 сарууд / Татварын ерөнхий газрын www.e-tax.mta.mn сайтыг ашиглан цахим тодорхойлолт /Хэвлэмэл хуудсыг үнийн саналын баримт бичигт ирүүлэх ба ингэхдээ хуудсын доод хэсэгт байрлах тоо, тэмдэгт орсон 36 оронтой нууц дугаарыг гаргацтай байхаар ирүүлнэ. Тодорхойлолт нь тендер нээсэн өдрийн байдлаар хүчин төгөлдөр байна. МУ-ын, эсхүл үүсгэн байгуулагдсан улсын хуулийн дагуу татвар, хураамж, төлбөрөө төлөөгүй бол тендерт оролцогчийг ерөнхий нөхцөл хангаагүй гэж үзнэ/

Тендерийн материалыг Цахим худалдан авах ажиллагааны систем (www.tender.gov.mn) хаягаар өөрийн ААН-ийн хувийн нууцлалын кодыг ашиглан нэвтэрч цахим хэлбэр (pdf)-ээр илгээнэ.

Сонирхсон этгээд нэмэлт мэдээллийг **2020 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн 09:00** цагаас **2019 оны 2 дугаар сарын 27ны өдрийн 18:00** цаг хүртэл авч болох бөгөөд Цахим Худалдан авах систем (www.tender.gov.mn)-ээр мэдүүлгээ **2020 оны 2 дугаар сарын 28–ны өдрийн 09:30 цагийн дотор ирүүлнэ үү.**

Монгол, Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг, 4-р хороо, Нийслэлийн нутгийн захиргааны
2-р байр Хангарди ордон, Утас: 88100762 , Факс: 11-323662
Имэйл хаяг: tugsoo8810@gmail.com